



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 43 (328)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Биеийн тамир, спортын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны арваннэгдүгээр сарын 18

№ 43 (328)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |  |     |
|------|--|--|-----|
| 558. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2003-10-30-ны хууль) |  | 933 |
| 559. | Биеийн тамир, спортын тухай (2003-10-31-ний хууль)   |  | 935 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 560. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай       | Дугаар 43 | 941 |
| 561. | Жагсаалт, үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 44 | 941 |
| 562. | Үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах тухай           | Дугаар 45 | 942 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 563. | Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11, 45.7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 03 | 942 |
|------|---|-----------|-----|

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 564. | Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг тайлбарлах тухай | Дугаар 23 | 945 |
|------|---|-----------|-----|

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 5 дахь заалт:

"5/ төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх."

2/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8, 9 дэх заалт;

"7/ өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн дагуу харьяа байгууллага, доод шатны албан тушаалтны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг шалгах;

8/ иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаархи мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх;

9/ хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах."



### 3/ 9 дүгээр зүйлийн 4, 5 дахь

хэсэг:

"4. Иргэд радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр болон тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргаж болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан өргөдөл, гомдолд амаар хариу өгч болох бөгөөд шаардлагатай бол шалгаж тодруулан бичгээр хариу өгч болно."

5/ 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4 дэх заалт:

"3/ төрийн тухайн байгууллага, албан тушаалтанд иргэн өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, гомдол гаргасан бөгөөд түүнийг дахин хянаж шийдвэрлэх үндэслэлгүй;

4/ өргөдөл, гомдолд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа."

**2 дугаар зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Захиргааны хариуцлагын тухай" гэсний дараа "Арбитрын тухай"; 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно" гэсэн 2 дахь өгүүлбэр; 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "гомдолд" гэсний дараа "овог, нэр"; 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Бичгээр" гэсний дараа " болон цахим сүлжээгээр дамжуулан"; 13 дугаар зүйлийн 1 дэх заалтын "хамаарах" гэсний дараа " болон албан ёсоор нийтэд зарласан асуудлаар гаргасан "; 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын "хамаарахгүй" гэсний дараа " бөгөөд албан ёсоор нийтэд зарласан асуудлаар гаргаагүй "; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хангаагүй" гэсний дараа ", 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар гаргаагүй" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйл:

### "4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

Энэ хуульд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "өргөдөл" гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх заалтад зааснаас бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг; Өргөдөл нь санал, мэдэгдлийн шинжтэй байж болно.

2/ "санал" гэж төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг;

3/ "мэдэгдэл" гэж Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан хүсэлтийг;

4/ "гомдол" гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг;

5/ "өргөдөл, гомдлыг шийдвэрлэх" гэж өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж, түүний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээ авсныг мэдэгдэж, энэ хуульд заасан хугацаанд багтаан хариу өгөхийг."

2/ 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Иргэд өргөдөл, гомдлоо төрийн тухайн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэхээр хууль тогтоомжоор тогтоож, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр албан ёсоор нийтэд зарласан асуудлаар гаргана. Төрийн байгууллага, албан тушаалтны хууль тогтоомжоор тогтоосон эрхлэх асуудлын хүрээг албан ёсоор нийтэд зарлаагүй нь тухайн асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй байх үндэслэл болохгүй."

**4 дүгээр зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Уулзах байранд" гэснийг "Иргэдийг хүлээн авах байранд"; 12 дугаар зүйлийн



8 дахь хэсгийн 1 дэх заалтын "6 цагийн дотор" гэснийг "ажлын нэг өдөрт багтаан" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "биечлэн" гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА** **С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын зохион байгуулалт, эдийн засаг, эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнд оролцогчдын хооронд үүссэн харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж

2.1. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "биеийн тамир" гэж нийгмийн соёлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүний бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний идэвхийг сайжруулах зорилгоор оюуны болон материаллаг үнэт зүйлийг бий болгох үйл ажиллагааг;

3.1.2. "спорт" гэж биеийн тамирын хөгжлийн үр дүнд бий болсон тэмцээн, түүнд тусгай журмын дагуу бэлтгэж, оролцох үйл ажиллагааг;

3.1.3. "мэргэжлийн спорт" гэж үзэгчдийн болон мэргэжлийн спортын байгууллагын ашиг сонирхлыг хангах, ашиг олох үндсэн зорилготой зөвхөн мэргэжлийн тамирчид оролцдог спортыг;

3.1.4. "үндэсний спорт" гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэстний онцлог шинжийг агуулсан спортыг;

3.1.5. "тамирчин" гэж спортоор системтэй хичээллэж, тэмцээнд оролцдог этгээдийг;

3.1.6. "өндөр зэрэглэлийн тамирчин" гэж спортын тодорхой төрлөөр системтэй хичээллэж, үндэсний болон олон улсын тэмцээнд тогтмол оролцдог, спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангиллын дагуу спортын мастераас доошгүй цол авсан тамирчныг;

3.1.7. "мэргэжлийн тамирчин" гэж спортын тодорхой төрлөөр мэргэшиж, түүгээрээ дагнан хичээллэн, тэмцээнд бэлтгэж оролцсоныхоо төлөө контрактны дагуу цалин хөлс, бусад мөнгөн урамшуулал авдаг тамирчныг;

3.1.8. "биеийн тамир, спортын байгууламж" гэж иргэн, тамирчид биеийн тамир, спортоор хичээллэх, тэмцээн явуулах зориулалттай заал, танхим, талбайг;

3.1.9. "ажилтан" гэж биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж байгаа болон биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг.

##### 4 дүгээр зүйл. Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, зарчим

4.1. Төрөөс биеийн тамир, спортын талаар дараахь бодлогыг баримтална:

4.1.1. биеийн тамир, спорт нь төрийн анхаарал, ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байх;

4.1.2. биеийн тамир, спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололт, үндэсний уламжлалд тулгуурлан хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх;

4.1.3. биеийн тамирыг хүн амын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэднийг хүмүүжүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, ажиллах чадварыг дээшлүүлэх үндэс болгон хувь хүний хөгжлийг хангахад чиглүүлэх;

4.1.4. спортын бодлогын үндэс нь тамирчдын сургалт-дасгалжуулалтыг үр өгөөжтэй явуулж, ур чадварыг нэмэгдүүлэн улс, олон улсын тэмцээнд амжилттай оролцох, Монгол орныг дэлхий нийтэд сурталчлахад чиглэх.

4.2. Төрөөс биеийн тамир, спортын талаар дараахь зарчмыг баримтална:

4.2.1. иргэдэд биеийн тамирын хүмүүжил олгох үйл явц тасралтгүй, залгамж шинжтэй байх;

4.2.2. биеийн тамир, спортыг хөгжүүлэхдээ биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын бие даасан, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах;

4.2.3. биеийн тамир, спортын бодлого, арга хэмжээ нь төрийн бүх шатны, биеийн тамир, спортын байгууллага болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжих.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Биеийн тамир, спортын удирдлага, тогтолцоо**

**5 дугаар зүйл. Биеийн тамир, спортын төрийн удирдлагын тогтолцоо**

5.1. Биеийн тамир, спортын төрийн удирдлагын тогтолцоо нь Улсын Их Хурал, Засгийн газар, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

**6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1. Улсын Их Хурал нь биеийн тамир, спортыг дэмжих талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. биеийн тамир, спортын үндэсний бодлогыг тодорхойлох;

6.1.2. биеийн тамир, спортын асуудлаар олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

**7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

7.1. Засгийн газар нь биеийн тамир, спортыг дэмжиж хөгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. биеийн тамир, спортын үндэсний бодлогыг хэрэгжүүлэх;

7.1.2. биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;

7.1.3. насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг байгуулан ажиллуулах;

7.1.4. олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчныг шагнаж урамшуулах болон үндэсний хэмжээний тэмцээний мөнгөн шагналын хэмжээ, түүнийг олгох журмыг тогтоох;

7.1.5. Монгол Улсад зохиогдох олон улс, дэлхий, тивийн болон үндэсний хэмжээний спортын тэмцээн, наадам зохион байгуулах талаар шийдвэр гаргах;

7.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

**8 дугаар зүйл. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

8.1. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.2. биеийн тамир, спортын үндэсний бодлогыг боловсруулах;

8.1.3. биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

8.1.4. биеийн тамир, спортын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлого боловсруулах, биеийн тамир, спортын анагаах ухааныг хөгжүүлэх;

8.1.5. биеийн тамирыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёс болгон хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**9 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх**

9.1. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь биеийн

тамир, спортын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд эрхлэн зохион байгуулах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

9.2. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, дүүрэгт биеийн тамир, спортын хороо, суманд биеийн тамир, спортын орон тооны бус арга зүйчтэй байна.

9.3. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараахь эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1. биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.3.2. бүх насны ангиллын биеийн тамир-чийрэгжүүлэлтийн нормативыг боловсруулан батлах;

9.3.3. улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх олгох;

9.3.4. биеийн тамир, спортын улсын мэдээллийн санг бүрдүүлэх;

9.3.5. хууль тогтоомжид заасан бусад эрх.

## 10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга биеийн тамир, спортын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

10.1.2. тухайн нутаг дэвсгэрийн хүн ам, байгууллага, хамт олныг биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулах, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах;

10.1.3. аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нь аймаг, нийслэл, дүүрэгт биеийн тамир, спортын хороог байгуулан ажиллуулах ба биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тухайн биеийн тамир, спортын хорооны удирдлагыг томилж, чөлөөлөх;

10.1.4. сумын Засаг дарга нь биеийн тамир, спортын орон тооны бус арга зүйчийг гэрээ байгуулан ажиллуулах, чөлөөлөх;

10.1.5. хүн амын дунд биеийн тамирын хөдөлгөөн өрнүүлэх, спортыг хөгжүүлэх хөтөлбөр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах;

10.1.6. нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын материаллаг бааз, боловсон хүчний чадавхийг сайжруулах арга хэмжээ авах, орон нутгийн онцлогт тохирсон спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;

10.1.7. биеийн тамир, спортын төрлүүдийг хөгжүүлэх чиглэлээр биеийн тамир, спортын холбоо болон бусад байгууллагатай хамтран ажиллах.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Биеийн тамир

#### 11 дүгээр зүйл. Боловсролын байгууллага дахь биеийн тамир

11.1. Бүх шатны боловсролын байгууллага нь хичээлийн агуулга, төлөвлөгөөндөө биеийн тамирын хичээлийг оруулна. Биеийн тамирын хичээлийн хугацааг боловсролын стандартаар тогтооно.

11.2. Бие бялдрын хувьд сул, эрүүл мэндийн магадлагаатай суралцагсад тэдний бие бялдарт тохирсон тусгай хөтөлбөрийн дагуу биеийн тамирын хичээлийг заана.

11.3. Бүх шатны боловсролын байгууллага нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.3.1. хичээлээс гадуурх биеийн тамир, спортын сургалтын ажлын секц, дугуйлангийн хэлбэрээр зохион байгуулж, энэ арга хэмжээнд зориулсан хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусгах;

11.3.2. оюутан, сурагчдын дунд төрөл бүрийн тэмцээн, наадам зохиох, тэднийг улс, аймаг, нийслэл, бүс нутгийн болон сум, дүүргийн тэмцээнд оролцоход туслалцаа үзүүлэх;

11.3.3. биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр гарган хэрэгжүүлэх.

#### 12 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир

12.1. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь зохион байгуулалт, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ажиллагчдыг биеийн тамираар хичээллүүлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг хөдөлмөрийн болон хамтын гэрээнд тусган хэрэгжүүлнэ:

12.1.1. ажиллагчдын биеийн тамир, спортоор хичээллэх бололцоог ханган, биеийн тамир, спортын тэмцээн зохион байгуулах;

12.1.2. өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа биеийн тамир, спортын байгууламж, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглуулах, шаардлагатай тохиолдолд биеийн тамир, спортын байгууллагын



20.1. Биеийн тамир, спортын арга хэмжээг хэвийн явуулахад шаардагдах хэмжээний төсвийг Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

20.2. Биеийн тамир, спортын зардлыг улсын болон орон нутгийн төсөвт бие даасан зүйл болгон батална.

20.3. Энэ хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4, 9.3, 16.3, 18.5-д заасан үйл ажиллагааг улсын төсвөөс, 10.1.2, 10.1.4, 10.1.5, 18.7, 18.9-т заасан үйл ажиллагааг орон нутгийн төсвөөс, бусад үйл ажиллагааг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хорооны өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлнэ.

20.4. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хорооны өөрийн үйл ажиллагааны орлогын хэмжээтэй холбогдуулан улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгаж болохгүй.

20.5. Олон нийтийн үүсгэл санаачлагаар "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх сан" байгуулж болно.

20.6. Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нь ашгийн төлөө бус байна.

## **21 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын барилга, байгууламжийг өмчлөх, эзэмших, ашиглах**

21.1. Биеийн тамир, спортын барилга байгууламж нь бүх төрлийн өмчийн байж болно.

21.2. Бүх шатны боловсролын байгууллагын барилгыг биеийн тамир, спортын байгууламжгүй барих, ашиглалтад хүлээн авах, төрийн өмчлөлд байгаа биеийн тамир, спортын байгууламжийг адил байгууламж барихгүйгээр буулгахыг хориглоно.

21.3. Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахдаа иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын байгууламжийг зохистой хүрээнд барихаар тусгана.

21.4. Биеийн тамир, спортын байгууламжийг сургуулийн өмнөх насны хүүхэд, сурагчид, окутан, тахир дутуу иргэд, ахмадуудад ашиглуулахдаа тухайн байгууллага нь хөнгөлөлт үзүүлнэ.

21.5. Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулахдаа тухайн барилга байгууламжийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах, иргэдийн эрүүл мэнд, нэр төр, алдар хүндэд гэм хор учруулах,

харгис хэрцгий байдал, хүчирхийллийн илэрхийлэл үүсэхээс урьдчилан сэргийлэх үүргийг барилга байгууламжийг эзэмшигч, ашиглагч болон тухайн арга хэмжээг зохион байгуулагчид хүлээнэ.

## **22 дугаар зүйл. Ажилтан, тамирчны нийгмийн баталгаа**

22.1. Ажилтан дор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

22.1.1. хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлог, гүйцэтгэсэн хөдөлмөрийнхөө чанар, хэмжээнд тохирсон цалин, нэмэгдэл хөлс, нөхөн олговор, тусламж, шагнал, урамшуулал авах;

22.1.2. орон нутгийн онцлогийг харгалзан нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллагаас нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг авах.

22.2. Тамирчин дор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

22.2.1. тамирчин олимпын наадам, дэлхий, тивийн аварга болон улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлбэл Засгийн газраас мөнгөн шагнал болон бусад байгууллагын урамшуулал авах;

22.2.2. үндэсний шигшээ багийн тамирчин цалин хөлс авах. Энэ заалт дасгалжуулагчид хамаарна;

22.2.3. тэмцээнд оролцох явцад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд эмчлүүлэх зардлыг хөдөлмөрийн гэрээний дагуу тамирчны харьяалагдах байгууллага гаргах.

## **23 дугаар зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн тамир, спортын эрх**

23.1. Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын харьяат иргэн болсноор Монгол Улсын нэрийн өмнөөс олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, олимпын наадамд оролцох эрх эдэлнэ.

23.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь Монгол Улсын хэмжээнд зохиогдож буй тэмцээнд зохих журмын дагуу оролцож болно.

23.3. Мэргэжлийн болон өндөр зэрэглэлийн гадаадын тамирчин, дасгалжуулагчийг биеийн тамир, спортын байгууллага гэрээгээр ажиллуулж болох бөгөөд энэ харилцаа нь олон улсын спортын байгууллагаас гаргасан дүрэм, журам, зааварт нийцсэн байна.

## **24 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**



24.1. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэлийг хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч болон шүүгч ногдуулна:

24.1.1 энэ хуулийн 11.1-ийг зөрчсөн албан тушаалтныг 40000-60000, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгох;

24.1.2 энэ хуулийн 12.1-ийг зөрчсөн албан тушаалтныг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох;

24.1.3 энэ хуулийн 15.2.5-ийг зөрчсөн тамирчныг 30000-50000 төгрөгөөр торгож,

спортын тэмцээнд оролцох эрхийг хасах эсэх асуудлыг зохих спортын холбооны дүрмээр зохицуулах;

24.1.4 энэ хуулийн 21.2, 21.5-ыг зөрчсөн албан тушаалтныг 40000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох.

24.2. Биеийн тамир, спортын албан ёсны бэлтгэл, сургуулилт, тэмцээний явцад иргэний эрүүл мэндэд учруулсан гэм хорыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд арилгана.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтын Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт "35.Биеийн тамир, спортын улсын хороо" гэж нэмсүгэй.

2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө, албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг энэ онд багтаан зохих журмын дагуу баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Жагсаалт, үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолын хавсралтын "Долоо. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хэсэг" бүлгийн "7.Монголросцветмет /ХХК/" гэснийг хассугай.

2. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолын хавсралтын 2.1.6-гийн эхний егүүлбэрийн "Монголросцветмет"

нэгдэлд холбогдох хэсгийг "Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар "Монголросцветмет" нэгдлийн үйлдвэрүүдийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, үр ашгийг дээшлүүлэх, тэдгээрийг түшиглэсэн хот, тосгодын соёл, боловсрол, үйлчилгээний зориулалттай барилга, байгууламжуудын хэвийн ажиллагааг алдагдуулахгүй, ажиллагсдын нийгэм, ахуйн нөхцлийг бууруулахгүй байхаар хувьчлах боломжийг "Монголросцветмет" нэгдлийн үйл ажиллагааны тухай хоёр улсын Засгийн газар хоорондын 1991 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Хэлэлцээрийн хүрээнд Оросын талтай зөвшилцөх" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**





2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

Дугаар 45

Үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

-Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт өөрчлөлт оруулан хамтарсан үйлдвэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах;

1. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолын хавсралтын 2.1.9-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

-Болгарын талтай хэлэлцэн тохиролцоо замаар хамтарсан үйлдвэрийг хувьчлах асуудлыг шийдвэрлэх.

**2.1.9. Монгол, Болгарын "Монголболгаргео" хамтарсан үйлдвэр**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

"Монголболгаргео" хамтарсан үйлдвэрийг өөрчлөн байгуулах, төрийн эзэмшлийн ногдол хувийг хувьчлахдаа дараахь зарчмыг баримтална:

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2003 оны 10 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 03

**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11, 45.7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

*Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим  
14 цаг 00 минут*

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд Д.Чилхаажав, Ж.Болдбаатар, В.Удвал, Ч.Дашням/илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяа, өргөдөл гаргагч иргэн О.Нямдаваа, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Мерен нарыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй" гэж хуульчлан тогтоож, үүнээс болж Монгол Улсын иргэн-гэрч нь төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх гэсэн хэм хэмжээ нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн тухайн хэм хэмжээг өргөтгөн тайлбарлаж зөрчсөн гэж үзэж байна.

**Нэг.Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороонд оршин суугч О.Нямдаваа 2003 оны 5 дугаар сарын 28-нд Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө:**

ЭБШ хуулийн 5.1.14-д: "Төрөл, садангийн хүн" гэж нэг гэр бүлд хамт амьдардаггүй эцэг эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, ач зээ, гуч, жич, төрсөн ах, эгч, дүү авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хэлнэ хэмээн тайлбарлав. Энд төрөл садан гэх дундаа таслалтай хоёр өөр үгийг нэг ижил агуулгаар тайлбарласан нь буруу байх ба тайлбарын агуулга нь хэт механик субъектив шинжтэй, төрөл саданг ойлгох ард түмний үндсэн ойлголттой зөрчилдөж байна. Энэ шалтгаанаар үл төгсөх маргаан үүсэх, төрөл, садангийн тоо төрөл /хуульд заасан/ улам өсөх нээлттэй байдлыг бий болгоосон байж болзошгүй байна.

"1.Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-д зааснаар Монгол Улсын иргэн нь "өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх" үндсэн эрхтэй.

Төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг зөвхөн гэрчид олгоод, процессын бусад оролцогчид, тухайлбал хохирогч, сэжигтэн, яллагдагч нарт үл хамааруулж, үл

Гэтэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7-д "Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр



олгосон нь ЭБШ хуулийн 35, 36, 42/ Үндсэн хуульд тунхагласан тэгш эрхийг зөрчиж тухайн тодорхой эрхийг нийт иргэдэд олгосныг зөрчиж явцуу болгосон байна. Ингэснээрээ Үндсэн хуулийн 1.2-ын шударга ёс, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн заалтыг давхар зөрчиж байна.

Монгол орны иргэдийн ахуй амьдрал бусад орнууд ялангуяа европын суурьшсан орны иргэдийнхээс огт өөр малчид хоёр, гурван гэрээрээ хот суурин газарт хашаанд мөн л 2-3 гэрээрээ гол төлөв хамт амьдардаг. Эдгээр нь эцэг, хүү, хүргэн, төрсөн ах дүүсийнх гээд ойр төрөл садангууд байдаг. Орон сууцанд ч гэсэн, орон байрны боломж муутайгаас эцэг эх, үр хүүхдүүд олноороо хамт амьдрах нь түгээмэл. Монголд хүмүүс айлаар чөлөөтэй орж гардаг, ийм учраас ахуйн шинжтэй хэрэг зонхилж гардаг. Хэрэг илрүүлэх арга, техник төдий л хангалтгүй байгаа одоо үед төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх иммунитетийг гэрч-оролцогчид олгож, Үндсэн хуулийн хэм хэмжээг өргөтгөсөн нь хэрэгт гэрчээр асуугдах хүн үл олодох, улмаар хэрэг илрэх боломж багасч, хууль үл хэрэгжих, ЭБШ хуулийн зорилго үл хэрэгжих, эмж журамгүй анархи байдал бий болох хэтийн муу балагтай гэж үзэж байна. Ийнхүү Үндсэн хуулийн 1.2-ын хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим байх заалт давхар зөрчигджээ.

2.ЭБШ хуулийн 5.1.11-д "Гэр бүлийн гишүүн-сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг хэлнэ хэмээн зааж тогтоосон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "Монгол Улсын иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй" гэснийг дараах байдлаар зөрчиж байна.

Бүх оролцогчид бус зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хамааруулж гэр бүлийн гишүүн гэдэг ойлголтыг тайлбарлаж, бусад оролцогчид хамааруулж хэрэглэх боломжгүй болгож, Үндсэн хуулийн тухайн хэм хэмжээг ЭБШ хуульд явцуу утгатайгаар, буруу хэрэглэсэн гэж үзэж байна. Энэ үндэслэлийг няцаах өөр хэм хэмжээ ЭБШ хуульд байхгүй байна" гэжээ.

**Хоёр. Үндсэн хуулийн цэцгийн дунд суудлын хуралдаанд УИХ-ын даргын 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 137 дугаар захирамжаар УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, УИХ-ын гишүүн Д.Мөрөн 2003 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:**

"1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэдээс эрх, эрх чөлөөгөө шүүхээр хамгаалуулах эрхийн тухай заасан байдаг. Тэр дундаа гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд оршиж байна гэж үзэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гэрч голлох үүрэг гүйцэтгэдэг, өөрөөр хэлбэл гэрч нь болсон үйл явдлыг үнэн бодитойгоор сэргээн тогтоох, гэмт этгээдийг олж илрүүлэхэд чухал үүрэг бүхий эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч юм. Гэрч нь гэмт хэрэг болсон нөхцөл байдал ба гэм буруутай этгээд, эсхүл хохирогчийн талаар хэрэгт ач холбогдолтой мэдээлэл өгч чадах боловч гэр бүл, эцэг эх, үр хүүхэд, ураг төрлийн хоорондын харилцааг хүндэтгэн хамгаалах үүднээс өөрийн гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй байхаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7-д хуульчилсан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "Монгол Улсын иргэн...гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх... эрхтэй" гэснийг өргөтгөн тайлбарласан гэж үзэх үндэслэлгүй байна гэж үзэж байна.

Эрх зүйн онолд Үндсэн хуулийн тухайн заалтыг өөр хуулиар тайлбарлах арга байдаг бөгөөд хууль тогтоогч Үндсэн хуулийн "гэр бүлийн гишүүд" гэдгийг Гэр бүлийн тухай хуульд гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг; "Төрлийн хүн" гэж гэрлэгчийн эцэг эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг; "садангийн хүн" гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг ойлгоно гэж тодорхойлон тайлбарласан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн "гэр бүлийн гишүүн" гэдэг тодорхойлолтын "төрөл



садангийн хүн” гэдэг нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй хамт амьдарч байгаа, өөрөөр хэлбэл, албан ёсоор нэг өрхийн бүртгэлтэй байгаа ач, зээ, гуч, жич, төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хамааруулсан ойлголт юм.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11-д “гэр бүлийн гишүүн” гэдэг нэр томъёонд “төрөл, садангийн хүн”-ийг хамааруулан тайлбарласан. Энэ тайлбар Гэр бүлийн тухай хуулийн “төрлийн хүн”, “садангийн хүн” гэсэн ойлголтыг тайлбарласантай нийцэж байгаа тул Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг ойлголтыг буруу хэрэглэсэн гэж үзэх үндэслэлгүй юм.

2.Гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим эрүүгийн эрх зүйд үйлчилдэг бөгөөд хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг тогтоох, түүнд зохих шийтгэлийг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй буюу эрүүгийн ял оногдуулахгүй байхад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа чиглэгддэг билээ. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчоор тодорхойлж, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэр бүлийн гишүүд тэдний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй байгаа нь эдгээр хүмүүсийн хоорондын ураг төрлийн болон амьдралын хамгийн ойр дотны харилцааг харгалзсан хуулийн энэрэнгүй байх зарчимтай холбоотой гэж үзэж байна.

Иймд хууль тогтоогч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гэр бүлийн гишүүн гэдэг ойлголтыг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид илүү хамааруулсан нь зөв юм” гэжээ.

**Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцсон өргөдөл гаргагч иргэн О.Нямдаваа:**

“1.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-д гэр бүлийн гишүүн гэдгийг зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчидтэй холбож хуульчилсан нь Үндсэн хуулиар нийт иргэдэд олгосон эрхийг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчид хийгээд жирийн иргэдэд хамааралгүй болгож, Үндсэн хуулийн дээрх заалтыг явцуу утгаар буруу хэрэглэсэн, мөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч бус эхнэр буюу нөхрийн нь төрөл, саданг орхигдуулсан байна. Энэ

заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, тэгш байдал...” гэсэн заалтыг давхар зөрчиж байна.

2.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэгт гэр бүлийн гишүүнд “төрөл, садангийн хүнийг” оруулан хуульчилсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг өргөжүүлж зөрчсөн, “төрөл”, “садан” гэсэн хоёр өөр үгийг нэг ойлголт болгож хэрэглэсэн нь буруу гэж үзэж байна” гэв.

**Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Мөрөн:**

“Эрх зүйн онолд Үндсэн хуулийн заалтыг салбар харилцааг зохилцуулсан бусад хуулиар тайлбарлах тохиолдол байдаг. Энэ үндсэн дээр “гэр бүлийн гишүүн”-ий тухай ойлголтыг Гэр бүлийн тухай хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан. Эдгээр хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөхгүй байгаа. Төрөл, садны хүн нь гагцхүү баг, хорооны захиргааны бүртгэлээр ам бүлд нь байгаа тохиолдолд гэр бүлийн гишүүн болох юм. Хамтран амьдарч байгаа хүмүүсийн тухайд гэр бүлээ батлуулаагүй бол албан ёсны гэр бүлд тооцохгүй юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11, 45 дугаар зүйлийн 45.7 заалтууд Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн гэж үзэхгүй байна” гэв.

## ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Их Хурлаас 2002 он 1 дүгээр сарын 10-ны өдөр баталж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөгдсөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д “Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” гэж заасны “...гэр бүлийн гишүүн, эцэг, эх үр хүүхэд, төрөл, садан...” гэсэн үгүүд егүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийн хэлбэрээр, холбогдох хүмүүсийг тоочин тодорхойлж бичсэн нь гэр бүлийн гишүүн биш “төрөл, садан”-г хамруулсан ойлголт болсон байх бөгөөд ингэснээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй



байх..." гэсэн заалтыг агуулгын хувьд дэлгэрүүлэн тайлбарласан гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-д "гэр бүлийн гишүүн" гэдгийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдуулан тодорхойлсон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байж болох" тухай заалтыг тухайн хуулиар зохицуулж, салбар эрх зүйн харилцааны зарим гол субъектыг тухайлан зааж хуульчилсан байна. Үндсэн хуулийн дээр дурдсан заалтаар олгосон эрхийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчдээс бусад Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид эдлэхийг хязгаарласан, хориглосон зүйл үгүй бөгөөд Үндсэн хуулийн тухайн хэм хэмжээг Эрүүгийн байцаан шийтгэх хууль явцуу утгатайгаар буруу хэрэглэсэн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **ДҮГНЭЛТ ГАРГАХ** нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн "Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй" гэсэн заалтын "төрөл, садангийн хүний" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван

зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-ийн "Гэр бүлийн гишүүн" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагаар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг хэлнэ" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГА**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**Д.ЧИЛХААЖАВ**

**Ж.БОЛДБААТАР**

**В.УДВАЛ**

**Ч.ДАШНЯМ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 91 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ** нь:

Нэг. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг дор дурьдсанаар тайлбарласугай.

1. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт заасан хүнийг санаатай алах үйлдэл нь

шууд буюу шууд бус санаатай байх бөгөөд гэмт үйлдэл, хохирогчийн үхэл хоёрын хооронд шалтгаант холбоотойн байхын гадна энэ хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх болон 93 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх шинжийг агуулаагүй байдгаараа ялгагдана.

Хүндрүүлэх нөхцөл байдалгүй тухайлбал, эр эмийн хардлага, хохирогчийн зүй бус үйлдэл, ажиллагаа, эсхүл хүмүүсийн хоорондын маргаан, үүнээс үүдэн гарсан зодооны явц дунд хүнийг санаатай алсан, түүнчлэн зовж тарчилсан хүнийг өөрийнх нь хүсэлтээр алсан үйлдлийг Эрүүгийн



хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт зааснаар зүйлчилж шийдвэрлэх ба энэ тохиолдолд мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн шинжгүй байх учиртай.

2. Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг санаатай алсан этгээдийн гэмт үйлдэл нь Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсгийн хоёр буюу түүнээс дээш хүндрүүлэх шинжүүдийг нэгэн зэрэг агуулж байвал тухайн хэсгийн аль тохирох заалтуудыг давхар хэрэглэн зүйлчлэх бөгөөд энэ нь гэмт этгээдэд оногдуулах ял шийтгэлийг хүндрүүлэн үзэх үндэслэл болно гэж үзвэл зохино.

3. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсгийн 91.2.1-д заасан **"шунахайн сэдэлтээр"** хүнийг алсан гэмт хэрэг нь хохирогчийн мөнгө, эд хөрөнгө, орон сууц эзэмших болон өмчлөх, өв залгамжлах зэрэг бусад эрхийг олж авах, эсхүл өр төлбөрөөс чөлөөлөгдөх, бага насны буюу өндөр настай, өвчин эмгэгтэй хүнийг тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөх зэрэг материаллаг зардал гаргахаас зайлсхийх гэсэн сэдэлтээр үйлдэгдэж болно. Тэгэхдээ хүн алах гэсэн шунахай санаа зорилго нь хохирогчийг алах гэмт үйлдлээс өмнө үүссэн байхыг анхаарах нь зүйтэй.

4. Мөн зүйл, хэсгийн 91.2.2-т заасан **"танхайн сэдэлтээр"** гэдгийг тодорхойлохын тулд юуны өмнө Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлд заасан "Олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн ..." үйлдэл байсан эсэхийг зөв тогтоох нь зүйтэй. "Танхайрах" гэдэг нь иргэд хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээгээр хэрэгжиж тогтсон ёс суртахууны болон хүмүүсийн зан үйлтэй холбогдох нийтээр хүлээн зөвшөөрсөн хэв журмыг зөрчин тухайн орчиндоо илтэд хүндэтгэлгүй хамаа бус хандсан, үйлдэлдээ элдэв цээртэй хараалын болон бусдын нэр төрийг басамжлан доромжилсон үгийг ичүүргүйгээр зарлан түгээх, бусад руу хүч хэрэглэн довтолох, зодох, ингэхдээ элдэв юмсыг эсхүл зэвсэг хэрэгсэл түүнтэй адилтгах зүйлсийг хэрэглэх, хэрэглэхээр завдах, эсхүл үнийгээ хатуу ширүүн үгээр илэрхийлэн орчны хүмүүсийг айлган сүрдүүлж түгшээх, жигшил дургүйцлийг төрүүлэх зэргээр хэрцгий догшин авирлан нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн шууд санаатай үйлдэл байхыг ойлгоно.

"Танхайн сэдэлтээр" хүнийг алах гэдэгт дээр дурьдсан танхайн үйлдлийн улмаас эсхүл ямар нэг онцлох учир шалтгаангүй буюу эсвэл хохирогчоос ямар нэг зүйл хүсэх, шаардах төдий үл ялих зүйлээр шалтгаан хүнийг алсан байхыг хамааруулна.

5. Мөн зүйл, хэсгийн 91.2.3-т заасан **"өс хонзонгоор"** гэдэг нь гэм буруутай этгээд бусдын хууль зүй, нийтийн ёс суртахуунд нийцсэн ба нийцээгүй ямар нэг үйлдэл эс үйлдэхүйн нь төлөө "өөрт нь таалагдаагүй" гэх сэдэлт үндэслэлээр дургүйцэн өсөрхөж хохирогчоос хариу авах, хорсол тайлах гэсэн зорилгоор хүнийг алсан байхыг ойлгоно.

Дээрх сэдэлт нь зөвхөн гэм буруутай этгээд хохирогч хоёрын хоорондын харилцаанаас төдийгүй удам гарал, ураг төрлийн болон найз нөхдийн хоорондын харилцаатай холбоотой асуудлаас үүдэн гарч болохыг ойлговол зохино.

Харин гэм буруут этгээд болон хохирогч нарын хоорондын эд зүйлийн болон ахуйтай холбоотой маргааны шинжтэй таарамжгүй харилцаанаас үүдсэн сэдэлтээр хүнийг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсгээр зүйлчлэх үндэслэл болно.

6. Мөн зүйл, хэсгийн 91.2.4-т заасан **"захиалгаар"** гэдэгт гэмт этгээд нь ямар нэг тодорхой этгээд буюу захиалагчийн хүсэлтээр түүнээс эдийн ба эдийн бус шан харамж болон тодорхой болзол бүхий амлалт авч хүнийг санаатай алсныг ойлгоно.

Захиалагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн 35.2 болон 37.4-т заасныг журамлан энэ хуулийн 91.2.4-т зааснаар ял шийтгэл оногдуулна.

7. Мөн зүйл, хэсгийн 91.2.5-д заасан **"хохирогчийн цус, эд, эрхтнийг ашиглах зорилгоор"** гэдэг нь гэмт этгээд өөрийн болоод бусдын бие, эд эрхтнийг нөхөн сэргээх, аль нэг эрхтнийг орлуулан сольж ашиглах зэргээр, эсхүл бусдад худалдаж ашиг олох гэсэн шунахай сэдэлтээр хүнийг шууд санаатай алсныг хэлнэ.

Хэрэв энэ хэргийг үйлдэх явцдаа хохирогчийг тарчилган зовоож онц харгис хэрцгий арга хэрэглэсэн байвал Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.12-т зааснаар давхар зүйлчлэх нь зүйтэй.



8. Мөн зүйл, хэсгийн 91.2.6-д заасан **"өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор"** гэдэгт өөрийн болон бусдын үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж байгаа гэмт хэргийг гэрчлэх буюу мэдээлж болзошгүй гэсэн, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд саад учруулж болзошгүй гэсэн сэдэлтээр хүнийг алахыг хамааруулан ойлгоно.

9. Мөн зүйл, хэсгийн 91.2.7-д заасан **"уулгалан довтолх буюу дээрэмдэх хэргийг үйлдэхдээ"** гэдэг нь гэмт этгээд зохион байгуулалттай, зэвсэг бүхий бүлэгт биечлэн оролцож иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад уулгалан довтолсон, эсхүл бусдыг дээрэмдэх гэмт хэргийг үйлдэх явцдаа хүнийг санаатай алсныг хэлнэ.

Эдгээр нь биеэ даасан тусдаа гэмт хэрэг учир Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7 дахь заалтаас гадна мөн хуулийн 180 буюу 147 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилж нийлмэл гэмт хэрэг гэж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой.

Уулгалан довтолх гэмт хэргийн бүрэлдэхүүний бусад гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрүүдээс ялгагдах гол шинж нь "заавал зэвсэглэсэн бүлэг" байхаас гадна иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад халдан довтолж гэсэн гэмт санаа зорилгоор зохион байгуулагдсан байна.

Хэрэв үйлдсэн гэмт хэргээ нуух гэсэн санаа зорилгоор хүнийг санаатай алсан бол 91.2.6-д зааснаар давхар зүйлчилж байвал зохино.

10. Мөн зүйл, хэсгийн 91.2.8-д заасан **"хүн хулгайлах буюу бусдыг барьцаанд авах гэмт хэрэг үйлдэхдээ"** гэдэг нь хүн хулгайлах, эсхүл бусдыг барьцаанд авах гэмт хэргийг үйлдэх явцдаа хохирогчийг эсвэл өөр хүнийг санаатай алсан байхыг хэлэх ба гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ энэ заалтаас гадна Эрүүгийн хуулийн 108, 112 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилнэ.

Хэрэв хүн хулгайлах, хүнийг барьцаалах гэмт хэргийг үйлдэх явцад хүний амь насыг гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр хохироосон байвал энэ заалтад хамаарахгүй, харин Эрүүгийн хуулийн 108 дугаар зүйлийн 108.3, 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсгийн аль тохирохоор зүйлчлэх үндэслэл болно.

11. Мөн зүйл, хэсгийн 91.2.9-д заасан **"онц аюултай гэмт хэрэгтэн"** үйлдсэн гэдэг нь гэмт

этгээд Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 24 дүгээр зүйлд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор онц аюултай гэмт хэрэгтнээр нэгэнт тооцогдсон этгээд хүнийг санаатай алсан байхыг хэлнэ.

12. Мөн зүйл, хэсгийн 91.2.10-т заасан **"хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн"** гэдэгт урьд нь хүнийг санаатай алсан буюу алахаар завдсан /санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах гэмт хэрэг хамаарахгүй/ гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлсэн буюу шийтгүүлээгүй этгээд дахин энэ хэргийг үйлдэсний аль аль нь хамаарах бөгөөд уг этгээд эдгээр хэргийнхээ алинд ч Эрүүгийн хуулийн 72, 73, 76, 78 дугаар зүйлд заасан журмаар эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөгдөөгүй байна.

13. Мөн зүйл, хэсгийн 91.2.11-д заасан **"бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл"** гэдгийг Монгол Улсын Дээд шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолд тайлбарласнаар ойлгож хэрэглэнэ.

14. Мөн зүйл, хэсгийн 91.2.12-т заасан **"онц харгис хэрцгий аргаар"** гэдэгт хүнийг алахын өмнө буюу алах явцдаа хохирогчид олон тооны шарх, гэмтэл үүсгэж өвтгөн шаналгасан, тарчилган зовоосон, учруулсан гэмтлийн улмаас зовж зүдрэхээр байдал бий болгосон, ийм үйлчилгээ үзүүлэх бодис зориуд хэрэглэсэн, эсхүл өлсгөж цангаасан, осгоосон, амьдаар нь шатаан түлсэн, хайрсан, хохирогчийг тарчилгах зорилгоор түүнд бусдаас тусламж үзүүлэхэд санаатайгаар саад учруулсан, ойр дотнын хүмүүсийн нь дэргэд алж тэднийг сэтгэл санааны хувьд хүндээр шаналгасан зэрэг үйлдлийг хамааруулна.

Харин нэгэнт үйлдсэн гэмт хэргээ нуух зорилгоор хохирогчийн цогцсыг шатаасан, эрхтэнг салгасан явдлыг онц харгис хэрцгий арга гэж үзэхгүй.

15. Мөн зүйл, хэсгийн 91.2.13-т заасан **"нийтэд аюултай аргаар"** гэдэг нь гэмт этгээд тодорхой хүнийг алах гэсэн санаагаа хэрэгжүүлэхдээ хохирогчоос гадна бусад хүмүүсийн амь насанд бодитой аюул учруулж болох арга тухайлбал барилга байшин шатаасан, дэлбэлсэн, хорт хий болон бусад үй олноор нь хөнөөх чадал бүхий хими, биологийн зэвсэг



хэрэглэсэн байх ба гэм буруутай этгээд өөрийн энэ үйлдлийн хор холбогдлыг ойлгож ухамсарласан санаатай үйлдэл байна.

16. Мөн зүйл, хэсгийн 91.2.14-т заасан **“хохирогчийг жирэмсэн болохыг мэдсээр байж”** гэдэг нь гэмт этгээд хохирогчийн жирэмсэн гэдгийг түүний гадаад төрх байдал, хоорондын харилцаа эсхүл бусад эх сурвалжаас лавтай мэдэж байсан атлаа санаатай алсан байхыг хэлнэ.

17. Мөн зүйл, хэсгийн 91.2.15-д заасан **“хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж”** гэдэгт бага насны буюу өндөр настай, өвчин эмгэгтэй, эрхтэн дутуу, мөн биеийн ерөнхий хөгжлөөр үзтэл сул дорой эсхүл хүчтэй мансуурсан, согтуурсан болон бусад шалтгаанаар өөрийгөө хамгаалах, хянах чадваргүй болохыг нь мэдсээр байж хүнийг санаатай алсан байхыг ойлгоно.

18. Мөн зүйл, хэсгийн 91.2.16-д заасан **“хоёр буюу түүнээс олон хүнийг”** алсан гэдэг нь гэмт этгээд хоёр буюу түүнээс олон хүнийг алах гэсэн нэгдмэл нэг санаа зорилгоо нэг цаг хугацаанд эсхүл ямар нэг тодорхой цаг хугацааны дараа хэрэгжүүлсэн байхыг хэлнэ.

Хэрэв энэхүү санаа зорилгоо хэрэгжүүлэхдээ хохирогчдоос бусад хүмүүсийн амь биед аюултай арга хэрэглэсэн байвал 91.2.13-т зааснаар давхар зүйлчлэх нь зүйтэй.

19. Мөн зүйл, хэсгийн 91.2.17-д заасан **“албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын төрөл, садангийн хүнийг”** алсан гэдэг нь гэмт этгээд хохирогч, эсхүл түүний гэр бүл, үр хүүхэд, ах дүү, ойр дотнын хүнийг хохирогчийн гүйцэтгэж байсан албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлэх ажиллагааг нь зогсоох, түүнд саад болох, түүнчлэн энэхүү үүрэгтэй нь холбогдуулан хүнийг санаатай алахыг хэлнэ.

**“Албаны үйл ажиллагаа”** гэдэгт төрийн албан хаагч, олон нийтийн буюу аж ахуйн байгууллагын ажилтан ажил төрлийн хувьд хүлээсэн үүргээ хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг ойлгох бөгөөд **“олон нийтийн үүрэг”** гэдэгт тухайн хүнд тухайлан хүлээлгэсэн олон нийтийн сонгуульт болон бусад гүйцэтгэж байгаа үүргийг хамааруулан ойлгох нь зүйтэй.

Эрх мэдэл буюу албаны бүрэн эрхээ илтэд хэтрүүлсэн хохирогчийн буруутай үйлдэлд дургүйцэж алсан, түүнчлэн албаны үйл ажиллагаа, олон нийтийн үүргээ биелүүлж байсныг нь мэдээгүй, мэдэх боломжгүй байсан үед бусдыг санаатай алсан бол энэ заалтад хамаарахгүй.

Мөн бусдыг албаны үйл ажиллагаатай нь холбогдуулан алсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн өөр зүйл, хэсэгт бие даасан тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнтэйгээр тусгайлан гэмт хэрэг гэж заасан бол зөвхөн тэр зүйл, хэсгээр зүйлчлэх буюу давхар зүйлчилж шийдвэрлэнэ.

20. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд заасан хүнийг санаатай алах гэмт хэргийг шийдвэрлэхдээ гэм буруугийн хэлбэр, сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдсэн орон цаг, арга хэрэгсэл, хор уршиг, шалтгаант холбоо, гэмт этгээд болон хохирогчийн хувийн байдал, тэдгээрийн хоорондын харилцаа, ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлууд зэргийг тал бүрээс нь бодитой нягтлан тогтоосон байвал зохино.

Хоёр. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн заалтыг тайлбарлах тухай” Дээд шүүхийн Бүгд хурлын 1993 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 44 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**

**Ч.ГАНБАТ**

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Н.ТӨРБАТ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2